

татвар, хураамж гаргуулах тухай шаардлага тавих эрхийг өөртөө үлдээнэ.

Тавин тавдугаар зүйл

1. Хэрэв өв залгашслалын хэргийг шийдвэрлэсний дараа өвлүүлэх хөдлөх, үл хөдлөх хөрөнгө болон туунийг худалдсаны үнийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт байнга буюу тур оршин суугаа өв залгамжлагчид шилжуулэх бөгөөд хэрэв тэр өв хөрөнгө буюу худалдсаны үнийг шууд шилжуулэх нөхцөлгүй, эсхүл итгэмдлэгдсэн этгээд байхгүй бол уг зүйлийг тэрхуу Хэлэлцэн Тохирогч Этгээдийн дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт шилкуулвэл зохино.

2. Энэ зүйлийн I дэх ангийн заалтыг биелүүлэхэд доорх нөхцлийг бурдуулсан байвал зохино:

а/ өвлөх хөрөнгөнд оногдуулсан бух татвар, хураамжийг төлсөн буюу төлөх нөхцлийг хангасан байх;

б/ өвлүүлэх эд хөрөнгийг авч тарах буюу туунийг худалдсан мөнгийг шилжуулэх зөвшөөлийг эрх бүхий байгууллага олгосон байх.

Зургадугаар бүлэг

Шуухийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх

Тавин зургадугаар зүйл

Хүлээн зөвшөөрч гүйцэтгэх шийдвэр

I. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд энэхүү Гэрээнд зааснаар Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт гаргасан дор дурдсан шуухийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэнэ: